

## ЯПОНЫ АРДЧИЛАЛ

*Тэцүндэ Ивакуни\**

### **Товч оршил**

Ихэнх хүмүүс Японы ардчилал дэлхийн 2-р дайны дараа бий болсон гэж үздэг. Ардчилал тийм ч их нэвтрээгүй байсан Японд Холбоотнууд л түүнийг оруулж ирсэн гэдэг.

Энэ нь тодорхой хэмжээгээр үнэн байж болох ч ардчиллын үр хөврөл Японы нийгэмд бүр ХХ зууны эхэн үед бүрэлдэж байсан тул ардчилал, ардчилсан тогтолцоонд харьцангуй хялбар шилжсэн гэдгийг онцлон тэмдэглэвэл зохино.

Хэт үндсэрхэг, миллитарист засаглалаас ардчилал руу шилжихэд дөхөм үзүүлсэн өөр нэгэн хүчин зүйл бол хаант засаглалаа хэвээр хадгалсан явдал юм. Хэдийгээр эдүгээ гол төлөв бэлэг тэмдгийн чанартай болсон ч энэхүү хаант засаглал нь дайны дараах үймээн самуунтай, их өөрчлөлтийн үед япончуудад тогтворжуулагч нөлөө үзүүлсэн билээ.

### **Японы ардчиллын бэхжилт**

Японы нийгэмд ардчилал бат бэх төлөвшсөнөөс хойш 60 гаруй жил болжээ. Энэхүү ардчиллын чанар, бодит байдал, үр дүн зэрэг нь хэр байна вэ? Санаа зовох шалтгаан байна уу?

Ардчилсан улс орнуудын зарим нийтлэг шалгуурыг авч үзэхэд Япон улс нь ардчилсан зарчим, бүтэц, үйл явцынхаа хувьд тогтвортой ардчилал бүхий улсуудын дунд нилээн дээгүүр зэрэглэлд багтаж байна. Тухайлбал,

1. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь боловсролын болон бичиг үсэг тайлагдалтын түвшин их өндөр.

2. Японы үндсэн хууль нь эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд улс төр, хөдөлмөрийн зах зээл, боловсрол зэрэгт эн тэнцүү оролцох эрхийг баталгаажуулсан байдаг.

3. Иргэний хөдөлгөөнүүд тун идэвхтэй байдаг тул нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн бус болон ашгийн бус байгууллагууд гарч ирдэг.

4. Хэвлэлийн эрх чөлөө - бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр учраас япончууд хэвлэл мэдээлэлд хялбар бөгөөд тогтмол хүрч чаддаг.

5. Иргэд сонгох, сонгогдох үйл явцад тогтмол оролцож байна. Сонгуулиуд нь ерөнхийдөө авилга, хүч хэрэглэх явдлаас ангид, шударга, чөлөөт байдлаар явагддаг.

---

\* Тэцүндэ Ивакуни - Япон улсын Төлөөлөгчдийн Танхимын гишүүн, Япон улсын Ардчилсан намын Гадаад харилцааны газрын ерөнхий захирал

### **Анхаарвал зохих асуудлууд**

Манай ардчилал хэрхэн “ажилладаг” талаар олон юм би нуршмааргүй байна. Харин бусад орны төлөөлөгчдөд зарим шийдвэл зохих асуудлууд илүү сонирхолтой бөгөөд чухал байх болов уу.

#### 1. Япон иргэдийн идэвхгүй байдал

Тогтвортой ардчилал бүхий аливаа оронд ийм зүйл ажиглагддаг. Ардчилал японы нийгэмд болон япон хүмүүсийн ухамсарт гүн бат шингэсэн учраас ардчиллыг хамгаалах шийдэмгий арга хэмжээ авах шааардлага Японд бараг байхгүй хэмээн хэн нэгэн боддог байж магадгүй юм.

Гэвч бидний мэдэхээр ардчилал гэдэг нь тогтсон бөгөөд хөдлөшгүй зүйл бас биш юм. Бат бөх тогтсон ардчилал ч гэсэн цагийн эрхээр суларч болно. Тиймээс ардчиллаа сонор соргог, идэвхитэй хамгаалж байх ёстой.

Ардчилал өөрийн гэсэн жам ёсны замнал буюу ардчиллыг бий болгохын төлөө тэмцэх, мөн ардчилсан тогтолцооны хүрээг тэлж бэхжүүлэх байдлаар явдаг бололтой. Гэвч хожим ардчилал бат суурьтай болох тусам ардчиллыг сахин хамгаалахын төлөө хичээл зүтгэл гаргаагүй хойч үеийнхэн түүнд тоомжиргүй буюу идэвхигүй хандах магадлал нэн их байдаг.

Япончуудын дунд 2 төрлийн тоомжиргүй буюу идэвхгүй байдал ажиглагддаг.

- Дэмжсэн тоомжиргүй байдал:

Удаан хугацаагаар засгийн эрхийг барьж байгаагийн улмаас Либерал ардчилсан нам ч, түүний дэмжигчид ч юу болохын байдаг л нэг бизнес мэт мэддэг ажээ.

- Үл итгэсэн идэвхгүй байдал:

Улс төрийн үйл явцад оролцох идэвх буурах өөр нэгэн шалтгаан бол итгэл алдрах явдал юм. Нэг нам 50 гаруй жил дангаар засгийн эрхэнд ноёлж байгаа учраас сонгогчид, ялангуяа залуу сонгогчид, энэ байдал хэзээ ч өөрчлөгдөхгүй тул санал өгөөд ч нэмэргүй гэж үзэхэд хүрдэг.

#### 2. Санал өгөх эрх дэх эрс ялгаатай байдал

Японы сонгуулийн систем нь пропорциональ төлөөлөл болон жижиг сонгуулийн тойргуудын хослолоос бүрддэг. Анх энэхүү системийг сонгохдоо Дээд Танхимын гишүүдийн тоо тухайн сонгуулийн тойргийн хүн амын тооноос хамаарч байхаар тооцоолжээ.

Гэвч бусад улс орнуудын адил манайд хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн болсон юм. Жишээ нь:

- 700 000 хүн ам бүхий хөдөөгийн тойргоос Дээд Танхимын 2 төлөөлөгчийг сонгодог.

- Дээрхээс 10 дахин их хүн амтай буюу 7 сая хүнтэй хотын тойргоос Дээд Танхимын ердөө 10 төлөөлөгчийг сонгож байна.

Өөрөөр хэлбэл, хүн амын статистикаас авч үзэхэд хотын тойргуудтай харьцуулбал хөдөөгийн тойргууд Дээд Танхимд 2 дахин илүү төлөөлөлтэй байна.

Эндээс Японы улс төрийн үндэс суурь хаана төвлөрч байгаа дүр зураг харагдаж байна. Улс төр хотод бус хөдөөд, аж үйлдвэрийн бус хөдөө аж ахуйн бүсэд, дэвшилт гэхээс илүү хуучинсаг газарт төвлөрч байна.

Иймэрхүү хуваарилагдсан төлөөлөл нь Засгийн газар яагаад тариачдад их татаас өгдөг, ямар учраас хөдөө нутагт улсын төсвөөр хийх ажлыг тэгш бусаар ахиухан хуваарилдагын тайлал юм. Зарим нэгэн эдгээр бүс нутгуудаас мөн л хамгийн хуучинсаг сонгуулийн тойргуудыг олж харах болно.

Том улс төрд орохоосоо өмнө улс төрийн хувьд Японы хамгийн консерватив мужуудын нэгд тооцогдох газарт хүүхэд насаа өнгөрөөж, тэндхийн хотын даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж байсан учраас эдгээр бүс нутгуудын хүн амын дунд күнзийн ёсны үүрэг, хариуцлагыг чухалд үзэх хийгээд зөрчлөөс зайлсхийж статус квог хадгалах үзэл өнөөг хүртэл давамгайлсаар байдгийг би мэднэ.

Хүн ам зүйн шилжилт хөдөлгөөн санал нэг бүрийн үзүүлэх жин нөлөөнд төдийгүй сонгуулийн хэв маягт ч нөлөөлж байна.

Дээр дурдсанчлан япон иргэдийн идэвхгүй байдал сонгуульд оролцогчдын тоо багасахад хүргэсний дотор хөдөө орон нутгийг бодвол хотод энэ бууралт илүү их ажиглагдаж байна. Бүр эхнээсээ орон нутгийн буюу хөдөө аж ахуйн бүсүүдэд сонгуульд оролцогчдын тоо хамгийн өндөр байсан юм. Сүүлийн 30 жилд энэ тоо яг 80 хувиас 70 хувь болж буурав. Харин хотод амьдарч буй ахмад үеийнхэн мөн хугацаанд 70 хувиас 50 хувь боллоо 20 хувиар буурсан үзүүлэлт дээрх хөдөөгийн тооноос мөн ялгарч байна. Хотууд дахь залуу сонгогчдын сонгуулийн идэвх бүр их буюу 60 хувиас 30 хувь боллоо 30 хувиар буурчээ.

Эдгээр тоо баримтад нэг их гайхаад байх хэрэггүй болов уу. Бусад орнуудад ч гэсэн үүнтэй адил зүйл гарч байгаа гэдэгт би итгэж байна. Сонгуульд оролцогчдын насны ангилал дунд хижээл насны сонгогчид ихтэй газарт болон үе үеийн сонгогчидтойгоо нягт холбоотой нутгийн улс төрчид өрсөлдөж буй тэр газруудад сонгуулийн идэвх ихэвчлэн өндөр гардаг. Харин улс төрийн гэр бүлийн хэлхээ холбоо сул болон залуу сонгогчид төвлөрсөн газруудад сонгуулийн идэвхи доогуур гарах нь нийтлэг юм. Гэхдээ дараах 2 зүйлийг нэгтгэн авч үзвэл тун ноцтой байдал ажиглагдаж байна.

1. Хөдөө орон нутгаас тэгш бусаар хэт олон төлөөлөгч сонгогдох;
2. Хотуудад сонгогчдын идэвх харьцангуй ихээр буурах;

Эдгээрийг нэгтгэн авч үзвэл орон нутгийн тойргуудад хотуудынхаас 3 дахин илүү сонгуулийн эрх мэдлийг өгч буй дүр зураг тодорч байна.

### **Цаашдын хөгжлийн чиг хандлага**

Энд тэмдэглэвэл зохих хамгийн сонирхолтой зүйл бол Японы ардчилсан тогтолцоо, дүрэм журам анхнаасаа сонгуульд оролцогчдын эрх тэгш байдлыг дээд зэргээр хангахад чиглэж байв. Үнэндээ АНУ-д өөрт нь сонгуулийн эн тэнцүү эрх, боловсролын эрх тэгш хүртээмжтэй байдал зэрэг эрх тэгш байдлын тогтолцоо хараахан бий болоогүй байсан тэр цаг үед ардчиллын тийм идеал загварыг Японд боловсруулж өгсөн байгаа юм. Хувь хүний эрхийг хамгаалах явдлыг баталгаажуулж, эрх мэдлийг хэтрүүлэн ашиглахаас урьдчилан сэргийлэх механизмыг ч мөн л нарийн боловсруулж хүчин төгөлдөр болгосон юм.

Эдгээр анхлан тавьсан зорилтууд болон бүтцийн хамгаалалтыг үл харгалзан энэхүү систем урьдчилан таамаглаагүй, сөрөг үр дагаврыг бий болгосон байгааг бид харж байна. Хүн амын шилжилт хөдөлгөөн нь хүн ам бага суурьшсан, илүү уламжлалт консерватив бүс нутгуудад Японы улс төрийн эрх мэдлийн нэлээд хэсэг төвлөрөхөд хүргэж байна. Эргээд энэ нь Япон улсад нэг нам засгийн эрхэд удаан хугацаагаар ноёлж байгаа байдлыг эвдэхэд сөргөөр нөлөөлж байна.

Ардчиллын энэ аажим зэврэлтийг зогсоохын төлөө одоо л хамгдаа хүчин чармайлт гаргахгүй бол аюултай мушгирсан уналт гарч болох юм.

- Энэхүү чиг хандлагыг үргэлжлэхийг хэр удаан зөвшөөрнө, төдий чинээ энэ байдлыг засч залруулахад хэцүү байх болно.

- Энэхүү байдал хэр удаан үргэлжилнэ, төдий чинээ хотын залуу сонгогчдын итгэл улам бүр алдарч, улс төрийн үйл явцад оролцох нь буурах болно.

- Энэ нь эргээд хөдөө орон нутгийн сонгогчдын жин нөлөөг улам нэмэгдүүлэх болно.

- Ийм мөчлөг үргэлжилсээр байх болно.

Эрх мэдлийг ил тод хэтрүүлэн ашиглах болон сонгуулийн эрхийг хасах зэрэгтэй тэмцэхэд үнэндээ илүү хялбар. Японы хувьд ардчиллын энэхүү зэврэлт нь нөгөө л ардчилсан бүтэц, хууль, дүрэм журмаар халхлагдсан байдаг.

### **Зайлшгүй хийх дараагийн алхмууд**

Юуны түрүүнд энэхүү бий болоод байгаа тэгш бус байдлыг олны анхааралд хүргэх хэрэгтэй. Сөрөг намууд энэ тал дээр ажиллаж байгаагийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд илүү идэвхтэй оролцох хэрэгтэй.

Дараа нь хувьсан өөрчлөгдөж буй хүн ам зүйд тулгуурласан сонгуулийн эрх тэгш хуваарилалтыг бий болгоход чиглэсэн тохирох аргыг боловсруулах хэрэгтэй. Үнэн хэрэгтээ ийм механизмууд аль хэзээний байдаг боловч эдгээр нь эрх баригч намын удирдлага дор байдаг учраас ямар ч нэмэр байхгүй.

Одоогийн үүсээд буй нөхцөл байдлууд нь сонгогчдын саналын үнэ цэнэд итгэх итгэлийг л доройтуулсаар байна. Эцсийн эцэст бид санал нэг бүр хийгээд ардчилсан системдээ бүхлээр нь итгэх иргэдийн итгэлийг эргүүлэн сэргээж, эдгээр итгэл алдрах, бухимдах, ичгүүргүй загнах явдлыг халах ёстой.

Маш их итгэл найдлага байсаар байна. Саяхан хийсэн санал асуулгаар сөрөг намууд эрх баригч намаас илүү ард иргэдийн дэмжлэгийг авч байгааг харуулсан нь бидэнд жинхэнэ өөрчлөлт шинэчлэлтийг хийх цаг үе ойртож байгаад итгэх шалтгаан олгож байна.

Эцэст нь бид ардчилсан практик, системийн үндэс суурийг тогтоох төдийгүй хадгалж хамгаалахад зохих ёсоор соргог байх ёстойг л хэлмээр байна. Япон орны амссан сургамж ардчиллын яг энэ үе шатанд ойртож буй бусад орнуудад ч гэсэн үнэ цэнэтэй хэмээн найдаж байна.

*(Их Британий Белфаст хотноо 2008.05.17-нд Олон улсын либерал конгрессын 55 дахь удаагийн хуралд тавьсан илтгэл)*

*Англи хэлнээс орчуулсан: Д.Ариунаа (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр)*